**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

## Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** ДГА-2019/126/СТА-ТШЗ


Цахим хуудас: www.audit.mn
Сайншанд хот
2019 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа
Утас: 70522734 Цахим хаяг: Dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: Ц.Лүндэгмаа
Утас: 70523020 Цахим хаяг: Lundegmaa.Ts@audit.gov.mn
Аудитор: О.Нарангарав
Утас: 70523020 Цахим хаяг: Narangarav.O@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

# Агуулга


1 Аудитын гэрчилгээ ..... 3
2 Аудитын тайлан ..... 5
2.1 Оршил ..... 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 9
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 10
2.11 Шилэн дансны мэдээлэл ..... 10
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 10
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 10
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан ..... 12
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 12
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 13
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 15
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 17
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 18
3.5.1 Төсвийн гүйцэтгэлийн тайлан - Үндсэн ..... 18
3.5.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан - Нэмэлт ..... 20

# 1 Аудитын гэрчилгээ

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

2019.02.21 № 1-6/109

танай___________-ны №___________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ОНЦГОЙ
БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГА
А.ДАШНЯМ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Онцгой байдлын газар нь 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА

# 2 АУДИТЫН ТАЙЛАН

## 2.1 Оршил

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга А.Дашням-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.18-наас 2019.02.20–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитор О.Нарангарав хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.01-ны өдрийн 25/36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3** Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

**2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар нь *"орон нутагт гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, гамшгийн эмзэг байдал, эрсдэлийг бууруулах*" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, аймгийн Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээгээр Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт, эрх зүйн баримт бичиг хэрэгжүүлэх
- Удирдлагын манлайлал, хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхыг бэхжүүлэх

- Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах, олон нийттэй харилцах
- Гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалтын чадавхыг дээшлүүлж, бэлэн байдлыг хангах
- Гал түймэртэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлж, хүч хэрэгслийн бэлэн байдлыг сайжруулах
- Улсын нөөцийн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах
- Төсөв, санхүү, хангалт, аж ахуйн бодлого зохицуулалт
- Дотоодын ажил үйлчилгээ зохион байгуулах, хэрэгжүүлэх

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын Төсвийн тухай хууль
- Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд
- Сангийн сайдын тушаал
- Дээд шатны байгууллагын тушаал шийдвэрүүд

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт хөрөнгийн 0.2 хувиар сонгов.

Нийт хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь нийт орлого зарлагын дүнгээс их байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны Нийт хөрөнгө 4,391.5 сая төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 8,8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 0.2 хувиар тооцсон нь нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 0.2 хувиар тооцсонтой холбоотой юм

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 1 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг B30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 0 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 254.4 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 1 | 254.4 | |

### 2.8.1 <u>Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал</u>

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Төрийн албан хаагчийн албан тушаалын байрны хэрэглээний зардал болох гэрэл цахилгаан, ус, дулааны зардлыг байгууллагын тогтмол зардлаас шилжүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Үнэн зөв байдал, Тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн:** <u>Төлбөрийн акт тогтоох</u>

## 2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

## 2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 8 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,875.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,730.9 сая төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь орон тоо дутуу ажилласантай холбоотойгоор цалин, НДШ-ийн зардал 144.5 сая төгрөгөөр хэмнэгдэж, үйл ажиллагааны зардал 0.1 сая төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн нь шалтгаалжээ.

## 2.11 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Онцгой байдлын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## 2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Онцгой байдлын газрын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС,

түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## 3.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ***ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН*** | ***705,863,920.00*** | ***550,540,517.47*** |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | - | - |
| 33 | АВЛАГА | 2,135,972.00 | 630,348.00 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | - | 300,000.00 |
| 335 | Бусад авлага | 2,135,972.00 | 330,348.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 2,135,972.00 | 330,348.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 703,727,948.00 | 549,910,169.47 |
| 351 | Түүхий эд материал | 501,030,376.96 | 436,909,798.33 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 500,249,744.66 | 436,137,336.21 |
| 35130 | Эм боох материал | 780,632.30 | 772,462.12 |
| 354 | Хангамжийн материал | 202,697,571.04 | 113,000,371.14 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,914,636.00 | 5,192,825.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 22,682,820.29 | 18,133,107.79 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 42,676,416.00 | 47,321,416.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 5,940,523.30 | 11,540,250.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,970,000.00 | 110,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 281,081.00 | 82,650.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 123,232,094.45 | 30,620,122.35 |
| 2 | ***ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН*** | ***3,849,937,099.90*** | ***3,840,961,655.60*** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,849,937,099.90 | 3,840,961,655.60 |
| 392 | Биет хөрөнгө | 3,849,937,099.90 | 2,321,069,155.58 |
| 39201 | Барилга, байгууламж | 3,339,756,496.00 | 1,419,883,156.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (659,601,939.93) | (36,703,226.89) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 1,948,938,761.85 | 1,900,631,187.15 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (1,283,988,029.01) | (1,427,641,823.00) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 1,622,739,922.92 | 1,738,816,775.92 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,143,005,797.72) | (1,295,414,318.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 83,012,194.16 | 67,303,227.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (57,914,508.37) | (46,750,512.13) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 996,200.00 | 1,502,140.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (996,200.00) | (557,450.64) |
| 393 | Биет бус хөрөнгө | - | 1,519,892,500.02 |
| 39301 | Програм хангамж | 2,444,500.00 | 2,719,500.00 |
| 39302 | Хасагдуулга | (2,444,500.00) | (2,471,999.98) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | 1,519,645,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,555,801,019.90** | **4,391,502,173.07** |
| 4 | ***НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН*** | ***33,963.33*** | ***207,800.00*** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 33,963.33 | 207,800.00 |
| 413 | Өглөг | 33,963.33 | 207,800.00 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 33,963.33 | - |
| 4136 | Бусад өглөг | - | 207,800.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 207,800.00 |
| 5 | ***ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН*** | ***4,555,767,056.57*** | ***4,391,294,373.07*** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 4,555,767,056.57 | 4,391,294,373.07 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 1,045,314,256.78 | 2,564,959,256.78 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 1,045,314,256.78 | 2,564,959,256.78 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 3,274,071,649.06 | 1,378,638,544.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 3,274,071,649.06 | 3,276,439,319.06 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (1,897,800,774.74) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 236,381,150.73 | 447,696,571.97 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **4,555,801,019.90** | **4,391,502,173.07** |

## 3.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Балансын зүйл | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,304,268,934.90** | **2,185,228,448.25** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **77,091,290.85** | **107,704,889.25** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 77,091,290.85 | 107,704,889.25 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 77,091,290.85 | 107,704,889.25 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 77,091,290.85 | 107,704,889.25 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,227,177,644.05** | **2,077,523,559.00** |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,673,835,900.00 | 1,882,643,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,673,835,900.00 | 1,882,643,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 551,090,835.00 | 139,656,229.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 188,928,100.00 | 3,912,997.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 24,523,285.00 | 18,987,140.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 317,139,255.00 | 102,075,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,500,195.00 | 14,681,092.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 2,250,909.05 | 55,224,330.00 |
| 133003 | Хөрөнгийн | 2,250,909.05 | 55,224,330.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,769,156,009.72** | **2,666,075,436.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,769,156,009.72** | **2,666,075,436.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,631,332,320.32** | **2,519,255,987.82** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,333,760,557.00** | **1,498,092,092.00** |
| 210101 | Цалин | 957,509,082.00 | 1,036,578,292.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 339,894,000.00 | 426,072,900.00 |
| 210105 | Гэрээтийн цалин | 36,357,475.00 | 35,440,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **31,704,480.33** | **37,570,625.67** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 4,242,307.00 | 6,115,866.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 482,639.00 | 760,235.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 561,799.00 | 608,192.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 111,497.00 | 135,630.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 26,306,238.33 | 29,950,702.67 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **127,755,902.00** | **139,202,767.30** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 19,010,889.00 | 28,073,800.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 101,118,434.00 | 100,557,201.30 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 7,626,579.00 | 10,571,766.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **46,370,724.60** | **138,528,656.08** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 2,317,281.60 | 4,990,731.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 39,871,010.00 | 40,113,316.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 3,474,433.00 | 3,556,957.40 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 708,000.00 | 832,500.00 |
| 210408 | Бараа материал актасны зардал | - | 89,035,151.68 |
| **2105** | **Нормативт зардал** | **83,111,349.61** | **168,820,760.45** |
| 210501 | Эм | 411,902.70 | 417,086.10 |
| 210502 | Хоол | 14,438,379.00 | 16,333,044.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 68,261,067.91 | 152,070,630.35 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **65,226,758.25** | **28,602,677.28** |
| 210601 | Багаж хэрэгсэл | - | 8,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 65,226,758.25 | 28,594,177.28 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **39,276,100.00** | **107,668,400.00** |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 39,276,100.00 | 107,668,400.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж** | **412,148,940.00** | **11,176,050.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 405,663,315.00 | 3,076,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,045,200.00 | 1,684,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 1,662,525.00 | 1,701,150.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,160,900.00 | 1,170,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 695,200.00 | 707,200.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 1,180,200.00 | 1,719,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 741,600.00 | 1,116,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **491,977,508.53** | **389,593,959.04** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 35,314,683.00 | 3,944,650.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,118,900.00 | 2,655,230.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 455,543,925.53 | 382,994,079.04 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **137,823,689.40** | **146,819,448.67** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,780,000.00 | 2,200,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,980,000.00 | 2,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 46,800,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 89,043,689.40 | 144,619,448.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 89,043,689.40 | 144,619,448.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **(464,887,074.82)** | **(480,846,988.24)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)** | **740,053,253.29** | **-** |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 740,053,253.29 | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **1,416,953,786.50** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 3,942,966.21 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | - | 1,413,010,820.29 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)** | **740,053,253.29** | **(1,416,953,786.50)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)** | **275,166,178.47** | **(1,897,800,774.74)** |

## 3.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,224,926,735.00** | **2,022,299,229.00** |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,224,926,735.00 | 2,022,299,229.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,673,835,900.00 | 1,882,643,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,673,835,900.00 | 1,882,643,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 551,090,835.00 | 139,656,229.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж | 188,928,100.00 | 3,912,997.00 |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 24,523,285.00 | 18,987,140.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 317,139,255.00 | 102,075,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 20,500,195.00 | 14,681,092.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА 6а ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **2,212,799,935.00** | **2,019,879,229.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,212,799,935.00** | **2,019,879,229.00** |
| **210** | **БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,074,976,245.60** | **1,873,059,780.33** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,333,760,557.00** | **1,498,514,640.00** |
| 210101 | Үндсэн цалин | 957,509,082.00 | 1,037,000,840.00 |
| 210102 | Нэмэгдэл | 339,894,000.00 | 426,072,900.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 36,357,475.00 | 35,440,900.00 |
| **2102** | **Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл** | **31,670,517.00** | **37,604,589.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 4,242,307.00 | 6,115,866.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 482,639.00 | 760,235.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 561,799.00 | 608,192.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 111,497.00 | 135,630.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 26,272,275.00 | 29,984,666.00 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **130,926,362.00** | **143,285,006.00** |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 22,040,289.00 | 25,937,828.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 101,255,494.00 | 106,775,412.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 7,630,579.00 | 10,571,766.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **36,697,423.60** | **40,216,239.40** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,726,109.60 | 1,998,249.40 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,788,881.00 | 33,29,332.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,474,433.00 | 3,556,158.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 708,000.00 | 832,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **16,021,541.00** | **16,825,583.00** |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 559,745.00 | 522,630.00 |
| 210502 | Хоол, хүнс | 13,124,283.00 | 15,881,540.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,337,513.00 | 421,413.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **15,511,270.00** | **3,331,599.93** |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 100,000.00 | 261,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | - | 30,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,411,270.00 | 3,040,599.93 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **39,276,100.00** | **107,668,400.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 39,276,100.00 | 107,668,400.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **435,545,435.00** | **18,633,250.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 429,059,810.00 | 10,534,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,045,200.00 | 1,684,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,662,525.00 | 1,701,150.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,160,900.00 | 1,170,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 695,200.00 | 707,200.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,180,200.00 | 1,719,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 741,600.00 | 1,116,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **35,567,040.00** | **6,980,473.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 34,053,140.00 | 4,916,273.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх | 1,513,900.00 | 2,064,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **137,823,689.40** | **146,819,448.67** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 48,780,000.00 | 2,200,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,980,000.00 | 2,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 46,800,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 89,043,689.40 | 144,619,448.67 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 89,043,689.40 | 144,619,448.67 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **12,126,800.00** | **2,420,000.00** |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **12,126,800.00** | **2,420,000.00** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 12,126,800.00 | 2,420,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 12,126,800.00 | 2,420,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,126,800.00 | 2,420,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(12,126,800.00)** | **(2,420,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **(0.00)** |
| ***9*** | ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл*** | **-** | **-** |
| ***10*** | ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл*** | **-** | **-** |

## 3.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2017 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл** | **1,045,314,256.78** | **152,345,248.00** | **3,004,742,800.77** | **4,202,402,305.55** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 3,537,669.82 | **3,537,669.82** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,045,314,256.78 | 152,345,248.00 | 3,008,280,470.59 | **4,205,939,975.37** |
| Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | 84,035,902.73 | - | **84,035,902.73** |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 275,166,178.47 | **275,166,178.47** |
| **2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,045,314,256.78** | **236,381,150.73** | **3,274,071,649.06** | **4,555,767,056.57** |
| **2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **1,045,314,256.78** | **236,381,150.73** | **3,274,071,649.06** | **4,555,767,056.57** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 2,367,670.00 | **2,367,670.00** |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,045,314,256.78 | 236,381,150.73 | 3,276,439,319.06 | **4,558,134,726.57** |
| Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн | - | 211,315,421.24 | - | **211,315,421.24** |
| Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | 1,519,645,000.00 | - | 1,897,800,774.74) | **(378,155,774.74)** |
| **2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл** | **2,564,959,256.78** | **447,696,571.97** | **1,378,638,544.32** | **4,391,294,373.07** |

## 3.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

### 3.5.1 Төсвийн гүйцэтгэлийн тайлан - Үндсэн

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,882,643,000.00 | 1,738,023,551.33 | 144,619,448.67 | 92.32 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 1,882,643,000.00 | 1,738,023,551.33 | 144,619,448.67 | 92.32 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 1,880,427,900.00 | 1,735,823,551.33 | 144,604,348.67 | 92.31 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,622,088,000.00 | 1,480,665,551.00 | 141,422,449.00 | 91.28 |
| 210101 | Үндсэн цалин | 1,160,574,200.00 | 1,019,151,751.00 | 141,422,449.00 | 87.81 |
| 210102 | Нэмэгдэл | 426,072,900.00 | 426,072,900.00 | - | 100.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,440,900.00 | 35,440,900.00 | - | 100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 40,712,900.00 | 37,604,589.00 | 3,108,311.00 | 92.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6,490,100.00 | 6,115,866.00 | 374,234.00 | 94.23 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 927,200.00 | 760,235.00 | 166,965.00 | 81.99 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 741,700.00 | 608,192.00 | 133,508.00 | 82.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 185,400.00 | 135,630.00 | 49,770.00 | 73.16 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 32,368,500.00 | 29,984,666.00 | 2,383,834.00 | 92.64 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 143,286,600.00 | 143,285,006.00 | 1,594.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 23,809,700.00 | 25,937,828.00 | (2,128,128.00) | 108.94 |
| 210302 | Түлш, халаалт | 104,829,700.00 | 106,775,412.00 | (1,945,712.00) | 101.86 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,647,200.00 | 10,571,766.00 | 4,075,434.00 | 72.18 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,556,100.00 | 35,556,099.40 | 0.60 | 100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,115,100.00 | 1,753,249.40 | 361,850.60 | 82.89 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 28,899,800.00 | 29,414,192.00 | (514,392.00) | 101.78 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 3,451,400.00 | 3,556,158.00 | (104,758.00) | 103.04 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,089,800.00 | 832,500.00 | 257,300.00 | 76.39 |
| 2105 | Нормативт зардал | 16,825,600.00 | 16,825,583.00 | 17.00 | 100.00 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 990,000.00 | 522,630.00 | 467,370.00 | 52.79 |
| 210502 | Хоол, хүнс | 15,384,200.00 | 15,881,540.00 | (497,340.00) | 103.23 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 451,400.00 | 421,413.00 | 29,987.00 | 93.36 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 3,751,600.00 | 3,751,599.93 | 0.07 | 100.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 420,700.00 | 536,000.00 | (115,300.00) | 127.41 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 641,500.00 | 30,000.00 | 611,500.00 | 4.68 |
| 210604 | Урсгал засвар | 2,689,400.00 | 3,185,599.93 | (496,199.93) | 118.45 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,605,400.00 | 2,605,400.00 | - | 100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,605,400.00 | 2,605,400.00 | - | 100.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 8,170,900.00 | 8,099,250.00 | 71,650.00 | 99.12 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,740,400.00 | 1,684,800.00 | 55,600.00 | 96.81 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,702,800.00 | 1,701,150.00 | 1,650.00 | 99.90 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,170,300.00 | 1,170,300.00 | - | 100.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 707,200.00 | 707,200.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 1,733,400.00 | 1,719,000.00 | 14,400.00 | 99.17 |
| 210807 | Газрын төлбөр | 1,116,800.00 | 1,116,800.00 | - | 100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,430,800.00 | 7,430,473.00 | 327.00 | 100.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,916,600.00 | 4,916,273.00 | 327.00 | 99.99 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,514,200.00 | 2,514,200.00 | - | 100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,215,100.00 | 2,200,000.00 | 15,100.00 | 99.32 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,215,100.00 | 2,200,000.00 | 15,100.00 | 99.32 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 2,215,100.00 | 2,200,000.00 | 15,100.00 | 99.32 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,882,643,000.00 | 1,882,643,000.00 | - | 100.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,882,643,000.00 | 1,882,643,000.00 | - | 100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,882,643,000.00 | 1,882,643,000.00 | - | 100.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |
| | АЖИЛЛАГСДЫН ТОО | 167.00 | 155.00 | 12.00 | 92.81 |
| | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.00 |
| | Гүйцэтгэх ажилтан | 150.00 | 138.00 | 12.00 | 92.00 |
| | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | - | 100.00 |

## 3.5.2 Төсвийн гүйцэтгэлийн тайлан - Нэмэлт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 139,656,229.00 | (139,656,229.00) | - |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | - | 139,656,229.00 | (139,656,229.00) | - |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | - | 139,656,229.00 | (139,656,229.00) | - |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 17,849,089.00 | (17,849,089.00) | - |
| 210101 | Үндсэн цалин | - | 17,849,089.00 | (17,849,089.00) | - |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 4,660,140.00 | (4,660,140.00) | - |
| 210401 | Бичиг хэрэг | - | 245,000.00 | (245,000.00) | - |
| 210402 | Тээвэр (шатахуун) | - | 4,415,140.00 | (4,415,140.00) | - |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 105,063,000.00 | (105,063,000.00) | - |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 105,063,000.00 | (105,063,000.00) | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | - | 12,084,000.00 | (12,084,000.00) | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | - | 12,084,000.00 | (12,084,000.00) | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 139,656,229.00 | (139,656,229.00) | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 139,656,229.00 | (139,656,229.00) | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 3,912,997.00 | (3,912,997.00) | - |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 18,987,140.00 | (18,987,140.00) | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 102,075,000.00 | (102,075,000.00) | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 14,681,092.00 | (14,681,092.00) | - |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - | - |